



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 12 дугаар сарын 31

Дугаар 03/15

Баян-Өндөр сум

Аймгийн Засаг даргын 2024-2028 оны  
үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:


1.Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг нэгдүгээр, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга (Б.Зоригтбаяр)-д ДААЛГАХ нь:

2.1.Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх;

2.2.Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг жил бүрийн хөгжлийн төлөвлөгөө, төсвийн хүрээний мэдэгдэл, орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх;

2.3.Хөтөлбөрийн биелэлтийг жил бүрийн IV улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах;

ДАРГА  Д.МӨНХБАТ

0170100159

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Ээлжит бус III хуралдааны 03/15 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**  
Удиртгал

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахад нэг талаас иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах, нөгөө талаас аймгийн хөгжлийн зөв бодлогыг хэрэгжүүлэх сайн засаглалыг бий болгох зарчмыг баримталсан. Уламжлалт хандлага, хэвшиж тогтсон арга барилдаа тулгуурлан төрийн үйлчилгээг хүргэхээс илүүтэй хүн төвтэй, үр дүнд суурилсан, ухаалаг шийдлийг ашиглан аймгаа хөгжүүлэхийг тус хөтөлбөрийн удирдлага болголоо.

Хөтөлбөрийг боловсруулахад Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг үндэслэсэн болно. Аймаг, орон нутгийн хэмжээнд тулгарч буй сорилтуудыг үр дүнтэй шийдвэрлэж, хөгжлийн тулгамдсан асуудлаа бүтээлчээр, хурдтай тогтвортой хэрэгжүүлэх зорилгоор 2024 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрт нийцүүлэн “ЭРДЭНЭТ-ХҮНИЙ ХӨГЖИЛ” уриатай боловсруулаад байна.

Аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийг батлан хэрэгжүүлснээр Орхон аймгийн иргэн бүр аймаг орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд, бүтээн байгуулалтын ажлын үр шимийг бодитойгоор хүртэж чаддаг, оролцоо, дуу хоолой нь орон нутгийн хөгжил дэвшилд хувь нэмэр болдог, төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэйгээр авч чаддаг болно. Хүний хөгжлийг хангасан, амьдрах таатай орчин бүрдэж, төрийн үйлчилгээний шуурхай байдал хангагдаж, төр иргэний хамтын ажиллагаа, ил тод, нээлттэй байдал дээшилнэ. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж тогтвортой, өрсөлдөх чадвартай ажлын байрны хүрээг өргөжүүлэн, бүс нутгийн нийгэм, эдийн засгийн интеграцид нэгдэн, зах зээлээ тэлж, эдийн засгийн чадамжаа нэмэгдүүлэх болно.

Орхон аймгийн хэмжээнд хэрэгжүүлэхээр тусгайлан тусгасан дараах томоохон төсөл, үйл ажиллагааг төлөвлөж байна.

1.“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэсэн үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулна.

2.Оюутын орд болон бусад хэсгүүдэд эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлж, нөөцийг тогтоож, ашиглалтад бэлтгэх ажлыг эхлүүлж, эрэл, хайгуулын ажилд дэвшилтэт техник, технологи, хиймэл оюун ухааныг нэвтрүүлнэ.

3.Эрдэнэт хотын цахилгаан хангамжийг сайжруулахад шаардлагатай 35кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудыг барьж ашиглалтад оруулна.

4.“Төлөвлөлттэй хот”, “Цэвэр агаартай хот”, “Ногоон хот” төслүүдийг хэрэгжүүлнэ.

5.“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хаягдлын шинэ сан байгуулна.

6. Үйлдвэрлэл, технологийн паркийг түшиглэн машин үйлдвэрийн бүтээгдэхүүн, барилгын материал үйлдвэрлэл, тоног төхөөрөмж ба бусад төрлийн металл, резин хийцийн эд ангийн үйлдвэрлэлийг дэмжсэн төслүүдийг хэрэгжүүлнэ.

7. "Сургалт-Эрдэм шинжилгээ - Үйлдвэрлэлийн цогцолбор" хотхоныг байгуулан шинжлэх ухаанд суурилсан оюуны үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

8. "Эрдэнэт спорт цогцолбор"-ыг шинээр байгуулна.

9. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг түшиглэн төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг өргөжүүлж "Хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналт-сэргийлэлтийн төв" байгуулна.

Орхон аймаг нь Хойд бүсийн тээвэр логистикийн зангилаа төв цэг болж, байгаль орчинд ээлтэй хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний зохистой бүтэц бүхий Эрдэнэт хотыг хөгжүүлнэ. Энэ хүрээнд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн өмч, татварын болон татварын бус орлого, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аймгийг эдийн засгийн хувьд бие даан хөгжих нөхцөлийг сайжруулна.

Бизнес эрхлэх орчин, нөхцөлийг бүхий л талаар дэмжин төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дэд бүтцийн болон нийгмийн үйлчилгээний төслүүдэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулах боломжийг нэмэгдүүлж, бизнесийн идэвхжилийг дэмжинэ. Төрийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааг уялдуулан засаглалыг сайжруулж, иргэдэд нийгмийн суурь үйлчилгээг ойртуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

### Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн агуулга

№	Бүлэг	Үйл ажиллагаа	Зорилтын тоо
1.	ХОЙД БҮСИЙН ХӨГЖИЛД ОРОН НУТГИЙН ОРОЛЦОО	Аймаг, орон нутгийн хөгжил	7
2.	ХҮНИЙ ХӨГЖИЛ	Гэр бүл, хүн амын бүлгүүд	14
		Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж	8
		Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг	5
		Тэгш хүртээмжтэй, чанартай боловсрол	11
		Эрүүл мэнд	8
3.	ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО	Хот төлөвлөлт, Газар зохион байгуулалт	10
		Үйлдвэрлэл, уул уурхай	7
		Дэд бүтэц	8
		Тээвэр, авто зам	5
		Хүнс, хөдөө аж ахуй	9
		Байгаль орчин, ногоон тогтвортой хөгжил	7
		Аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэл	7
		Шинжлэх ухаан, инновацид суурилсан Ухаалаг хот	6

4.	ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ЗАСАГЛАЛ	Хүний эрх, эрх чөлөө	9
		Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, ил тод байдал	5
		Цахим засаглал, төрийн үйлчилгээ	11
		Амар тайван, аюулгүй хот	10
		Батлан хамгаалах, гамшгийн үеийн бэлэн байдал	5

## **НЭГ.ХОЙД БҮСИЙН ХӨГЖИЛД ОРОН НУТГИЙН ОРОЛЦОО**

### **Аймаг, орон нутгийн хөгжил**

1.1.Аймгийн эдийн засгийн чадамж нэмэгдэнэ.

1.1.1.Бүс нутгийн нийгэм, эдийн засгийн интеграцид нэгдэн, зах зээлээ тэлнэ.

1.1.1.1.Зэс боловсруулах, металлурги- химийн үйлдвэр болон бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэр технологийн парк байгуулна.

1.1.1.2.“Сургалт-Эрдэм шинжилгээ - Үйлдвэрлэлийн цогцолбор” хотхоныг байгуулан, шинжлэх ухаанд суурилсан оюуны үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.1.1.3.Шилжин ирж суурьших иргэдэд ажиллаж, амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэн хүн амыг нэмэгдүүлнэ.

1.1.1.4.Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг түшиглэн төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг өргөжүүлж “Хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналт- сэргийлэлтийн төв” байгуулна.

1.1.1.5.Тээвэр логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлж, бүсийн импорт, экспортын тээвэрлэлтийн зангилаа хот болон хөгжинө.

### **ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖИЛ**

#### **Гэр бүл, хүн амын бүлгүүд**

2.1.Гэр бүлийн гишүүд болон хүн амын бүлгүүдийн нийгмийн оролцоо хангагдана.

2.1.1. Гэр бүлийн хөгжлийн цогц төвийн үйл ажиллагаа тогтмолжиж, гэр бүлд чиглэсэн олон талт үйл ажиллагааны чанар, хүртээмж нэмэгдэнэ.

2.1.1.1.Гэр бүлийн хөгжлийн цогц төвийг байгуулан ажиллуулж, гэр бүлд суурилсан хүний хөгжил, оролцоог нэмэгдүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэн гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

2.1.1.2.Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн, багуудад хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллуулж, салбар дундын болон хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулна.

2.1.1.3.Хүүхэд харах болон өдөр өнжүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн хөгжлийг дэмжих арга хэмжээг төр, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.

2.1.1.4.Залуучуудын боловсрол, хөгжилд дэмжлэг үзүүлэх, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоог хангах бодлогыг хэрэгжүүлнэ.

2.1.1.5.Эмэгтэйчүүдийн хөгжил, манлайлал, нийгмийн оролцоог нэмэгдүүлж, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжин эдийн засгийн чадавхыг дээшлүүлнэ.

2.1.1.6.Иргэд, олон нийтийн сэтгэл зүйн боловсролыг дээшлүүлж, сэтгэл зүйн зөвлөгөө болон сэтгэл заслын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.1.2.Ахмад настны хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, асаргаа сувилгааны чанар, хүртээмж сайжирч, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагаа өргөжиж нийгмийн оролцоо нэмэгдэнэ.

2.1.2.1.Ахмад настны амьжиргааг дэмжиж хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үзүүлэн нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ.

2.1.2.2.Ахмад настны асаргаа сувилгааны хувилбарт үйлчилгээг эрэлт, хэрэгцээ, нөхцөл байдалд үндэслэн хувийн хэвшлийн оролцоотойгоор гүйцэтгүүлж, тэдний эрүүл мэндийн болон нийгмийн хөгжлийг дэмжинэ.

2.1.3.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоо, хөдөлмөр эрхлэх боломж нэмэгдэж, орчны дэд бүтцийн хүртээмж сайжирна.

2.1.3.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан мэргэжлийн сургалт, дадлагажуулалт, хөдөлмөр эрхлэлтэд зуучлах үйлчилгээг өргөжүүлж, хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.

2.1.3.2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээнд нийцсэн дэд бүтэц, барилга байгууламжийн стандартыг төр, хувийн хэвшлийн байгууллагуудад мөрдүүлнэ.

### **Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж**

2.2.Аймгийн хэмжээнд ажилгүйдлийн түвшин буурна.

2.2.1.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн хүний нөөцийн чадавх дээшилж, тогтвортой, өрсөлдөх чадвартай ажлын байрны хүрээ өргөжсөн байна.

2.2.1.1.Бүтээмж, технологид суурилсан 400-аас доошгүй ажлын байрыг шинээр бий болгож, нийт 2500-аас доошгүй хүнийг ажлын байранд зуучилна.

2.2.1.2.Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн зах зээлийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж 200-аас доошгүй гарааны бизнесийг дэмжин хөгжүүлж, тогтвортой хөгжих нөхцөлийг бүрдүүлнэ.

2.2.1.3.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн, чадамжид суурилсан ажиллах хүчийг бэлтгэж, олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлж, бүтээлч санаачилга, хандлага, ур чадварыг хөгжүүлнэ.

2.2.1.4.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Хөдөлмөр зуучлалын төв”-ийг шинээр байгуулан ажиллуулж, зорилтот бүлгийн ажилгүй иргэд, оюутан, залуучууд, ахмадуудыг түр болон цагийн ажлын байранд холбон зуучлах ажлыг ажил олгогч, ажилтанд нийцтэй байдлаар зохион байгуулна.

2.2.1.5.Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт тогтолцоонд тулгуурлан хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, хөдөлмөрийн харилцааны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулна.

2.2.1.6.Зорилтот бүлгийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн халамжийн үйлчилгээг хүн төвтэй, үр ашигтай, хүртээмжтэй хүргэнэ.

### **Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг**

2.3.Нийтийн биеийн тамир, спортоор хичээллэгчдийг дэмжиж, хүн амын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлсэн байна.

2.3.1.Нэг хүнд ноогдох спортын заалны талбайн хэмжээ нэмэгдэнэ.

2.3.1.1.“Эрдэнэт спорт цогцолбор”-ыг шинээр ашиглалтад оруулан, нийтийн биеийн тамир, спортын арга хэмжээг иргэдэд сурталчилж идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлнэ.

2.3.1.2. Спортын авьяасыг нээн илрүүлэх, мэргэжлийн болон үндэсний спортоор хичээллэгчдийн оролцоо, амжилтыг нэмэгдүүлж, тэдэнд дэмжлэг үзүүлэн, шинэ тутамд хөгжиж байгаа цахим, хотын (урбан) спортын төрлүүдийг хөгжүүлнэ.

2.3.1.3. Аймгийн хэмжээнд өвлийн спортыг хөгжүүлэхэд шаардлагатай материаллаг баазыг бэхжүүлж, мэргэжлийн багш, дасгалжуулагчийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэн, “Эрдэнэт мөнгөн өвөл” аяныг жил бүр зохион байгуулж, хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

### **Тэгш хүртээмжтэй, чанартай боловсрол**

2.4. Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ.

2.4.1. Суралцах таатай орчин бүрдэж, багш хүүхдийн хөгжил хангагдана.

2.4.1.1. “Хамгийн сайн сургууль, цэцэрлэг-Гэрт ойр сургууль, цэцэрлэг”, “Нэг ээлж, цөөн хүүхэдтэй анги” үйл ажиллагааг хэрэгжүүлж, цэцэрлэг, сургуулийн бүлэг дүүргэлтийг багасгана.

2.4.1.2. Боловсролын салбарын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хийж, 7-оос доошгүй сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилгыг шинээр ашиглалтад оруулж, боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.4.1.3. Хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх, хүмүүжил, төлөвшлийг сайжруулж, эрх хамгаалал, аюулгүй байдлыг хангах, эх хэл, үндэсний өв уламжлал, эх оронч сэтгэлгээ, амьдрах ухаанд суралцуулах олон талт үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, сургуулийн менежментийг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

2.4.1.4. Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд сургалтын чанарыг дээшлүүлж Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийн онцлог хэлбэр, нөхцөл байдлаас үл шалтгаалан танхимын болон хувилбарт сургалтаар боловсролын үйлчилгээнд хамруулж, боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэнэ.

2.4.1.5. Бүх насны иргэдийг насан туршдаа суралцахуйн үйлчилгээнд хамруулах “Суралцагч сум, байгууллага” болох олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.4.1.6. Цэцэрлэг, сургуулийн хүүхдүүдэд шаардлагатай шим тэжээл, амин дэмээр баялаг хоолоор үйлчлэх нөхцөлийг бүрдүүлж, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг асран хамгаалагчтай хамтран хэрэгжүүлнэ.

2.4.1.7 “Багшийн 3 тулгуурт бодлого”-ын хүрээнд багшийн чанар, үнэлэмж, гүйцэтгэлийг сайжруулах “Сайн багшийг таны дэргэд” арга хэмжээг хэрэгжүүлж, Багшийн хөгжлийг дэмжих, урамшуулах, харилцан туршлага солилцох олон талт үйл ажиллагааг зохион байгуулна.

2.4.1.8. Суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгож, сонгох боломжтой төрөлжсөн ахлах сургуулийг байгуулж, төгсөгчдийг гадаадын их, дээд сургуульд суралцахад дэмжлэг үзүүлнэ.

2.4.1.9. Их, дээд сургууль, политехник коллежид хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжлийн хөтөлбөрийг нэвтрүүлж, чадвартай хүний нөөцийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.

### **Эрүүл мэнд**

2.5. Аймгийн хэмжээнд хүн амын дундаж наслалт нэмэгдсэн байна.

2.5.1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чадавх бэхжиж, зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулсан байна.

2.5.1.1. Иргэний эрүүл мэндийн боловсрол, эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжсэн нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог төлөвшүүлж, иргэдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

2.5.1.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо эмчилгээний техник технологийн дэвшлийг нэвтрүүлж, төвлөрлийг сааруулах, орон нутагтаа оношлох, эмчлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

2.5.1.3. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангаж, хяналтыг сайжруулна.

2.5.1.4. Иргэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг орон зай, цаг хугацаанаас үл хамааран авах боломжийг нэмэгдүүлж, цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологи телемедицин, хиймэл оюун ухааныг эмчилгээ, оношилгоо, хяналтад нэвтрүүлнэ.

2.5.1.5. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулж, дотоод болон гадаадад хүний нөөцийг бэлтгэн сургах, туршлага солилцох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.5.1.6. Нийгмийн эрүүл мэндийн төв болон 2 –оос доошгүй өрхийн эрүүл мэндийн төвийн барилгыг багийн нутаг дэвсгэрт нь ашиглалтад оруулан нийгмийн эрүүл мэнд, анхан шатны тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

### **ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** **Хот төлөвлөлт, Газар зохион байгуулалт**

3.1. Иргэдэд амьдрах таатай орчныг бүрдүүлсэн “Төлөвлөлттэй хот”-ыг бий болгоно.

3.1.1. Хот байгуулалтын норм дүрмийн хэрэгжилт хангагдана.

3.1.1.1. Эрдэнэт хотыг 2045 он хүртэл хөгжүүлэх “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулж батлуулна.

3.1.1.2. Ухаалаг хотын төлөвлөлтөд мөрдөгдөх жишиг зураг, төслийг боловсруулан батлуулж хэрэгжүүлнэ.

3.1.1.3. Хотын гудамж талбайн нэр, эд хөрөнгийн хаягжилтыг сайжруулан хаягийн нэгдсэн системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлнэ.

3.1.1.4. Иргэдийн орлогод нийцсэн болон ногоон амины орон сууцны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ипотекийн, ногоон зээлийн бодлогоор дэмжиж, хувийн хэвшилтэй хамтран ажиллана.

3.1.1.5. Барилгын материалын чанар, хяналт, шинжилгээний лабораторийн хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж, лабораторийн үйл ажиллагааг тогтворжуулна.

3.1.1.6. Аймгийн газар зохион байгуулалтын 2037 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

3.1.1.7. Газар ашиглалт, газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг сайжруулна.

3.1.1.8. Газар, үл хөдлөх, эд хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийн үйл ажиллагааг хангана.

### **Үйлдвэрлэл, уул уурхай**

3.2. Олон тулгуурт эдийн засагтай үйлдвэрлэгч хот болон хөгжинө.

3.2.1. Уул уурхай, үйлдвэрлэлийн салбарыг хослуулан хөгжүүлж импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэл хөгжинө.

3.2.1.1. Оюутын орд болон бусад хэсгүүдэд эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлж, нөөцийг тогтоож, ашиглалтад бэлтгэх ажлыг эхлүүлж, эрэл, хайгуулын ажилд дэвшилтэт техник, технологи, хиймэл оюун ухааныг нэвтрүүлнэ.

3.2.1.2. Үйлдвэрлэл, технологийн паркийг түшиглэн машин үйлдвэрийн бүтээгдэхүүн, барилгын материал үйлдвэрлэл, тоног төхөөрөмж ба бусад төрлийн металл, резин хийцийн эд ангийн үйлдвэрлэлийг дэмжсэн төслийг хэрэгжүүлнэ.

3.2.1.3. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хаягдлын шинэ сан байгуулах төслийг хэрэгжүүлнэ.

3.2.1.4. Жижиг, дунд, хөнгөн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн чадавхыг сайжруулж, хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжинэ.

3.2.1.5. Бүсчилсэн болон орон нутагт хэрэгжүүлэх татварын бодлогыг сурталчлан, татвар төлөгчийн эрсдэлийн түвшнээс хамааруулан сегментийн стратегийг хэрэгжүүлж, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжинэ.

### **Дэд бүтэц**

3.3. Дэд бүтцийн хүртээмж, найдвартай ажиллагаа нэмэгдэнэ.

3.3.1. Аймгийн хэмжээний эрчим хүч, инженерийн шугам сүлжээний 30-аас доошгүй хувийг шинэчилнэ.

3.3.1.1. Хотын инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.3.1.2. Хотын хэмжээнд үерийн хамгаалалтын далан сувгийн төлөвлөлтийг шинэчлэн боловсруулан шинээр барих ажлыг үе шаттайгаар хийж, ашиглалтыг сайжруулна.

3.3.1.3. Аймгийн цэвэрлэх байгууламжид системийн шинэчлэл хийж, бохирын гуравдугаар коллекторыг ашиглалтад оруулан усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөн шинэчилнэ.

3.3.1.4. Хотын цахилгаан хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлэхэд шаардлагатай 35кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, шугам, сүлжээг өргөтгөн, ухаалаг удирдлагын систем нэвтрүүлж, цахилгаан хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.3.1.5. Иргэн, аж ахуйн нэгжээс сэргээгдэх эрчим хүчийг жижиг, дунд төхөөрөмжөөр үйлдвэрлэж хэрэглэх, хэрэгцээнээс давсан хэсгийг худалдах боломжоор хангана.

3.3.1.6. Хот төлөвлөлтийн дагуу дулаан хангамжийн шугам сүлжээг өргөтгөн, ус, дулаан дамжуулах төвийг шинээр барьж ухаалаг системд шилжүүлэн ашиглалтыг сайжруулна.

### **Тээвэр, авто зам**

3.4. Тээвэр авто замын нөхцөл сайжирснаар иргэдийн ая тухтай, аюул осолгүй зорчих орчин бүрдэнэ.

3.4.1. Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмж сайжирч, автозам, замын байгууламж нэмэгдэнэ.

3.4.1.1. Нийтийн тээврийн үйлчилгээнд парк шинэчлэлт хийж, ухаалаг системийг нэвтрүүлэн, чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.



3.4.1.2.Аймгийн авто замын барилга угсралт, шинэчлэлт, өргөтгөл, их засварын ажлыг хийж, замын дагалдах дэд бүтцийг стандартын дагуу байгуулна.

3.4.1.3.Хотын дотор болон амралт, зугаалгын бүсүүдэд явган хүн, унадаг дугуйн замыг нэмэгдүүлнэ.

#### **Хүнс, хөдөө аж ахуй**

3.5.Хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангана.

3.5.1.Хүн амын хүнсний чанар, аюулгүй байдал хангагдана.

3.5.1.1. "Хүнсний хангамж аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангана.

3.5.1.2.Газар тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, хүрсэн түвшинг тогтворжуулан хөгжүүлнэ.

3.5.2.Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, түүхий эд бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлагыг хангана.

3.5.2.1."Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд хоршоодыг дэмжин, малчдыг үйлдвэрлэгч өрх болгон хөгжүүлж, орлогыг нэмэгдүүлнэ.

3.5.2.2.Малын үүлдэр угсааг сайжруулж, эрчимжсэн аж ахуйг дэмжин мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

3.5.2.3.Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалж, малын халдварт өвчингүй тайван байдлыг хадгална.

3.5.2.4.Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг ханган ажиллана.

#### **Байгаль орчин, ногоон тогтвортой хөгжил**

3.6.Хүрээлэн буй орчинд ээлтэй "Ногоон хот"-ыг бий болгоно.

3.6.1.Байгалийн нөөц баялгийг зохистой ашиглуулж, нөхөн сэргээлтийг эрчимжүүлэн, хүрээлэн буй орчны бохирдол, доройтол буурна.

3.6.1.1."Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, ногоон Эрдэнэт хөтөлбөрийг эрчимжүүлж, эко системийн тэнцвэртэй байдлыг хадгалах санаачилгыг дэмжинэ.

3.6.1.2.Усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, гадаргын усыг хуримтлуулан хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.6.1.3.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудын нөхөн сэргээлтийг эрчимжүүлнэ.

3.6.1.4.Орчны чанар, төлөв байдлыг тодорхойлж, "Цэвэр агаартай хот" төслийг хэрэгжүүлэн орчны бохирдлыг бууруулна.

3.6.1.5.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах, байгальд ээлтэй хэмнэлттэй ногоон технологийг бодлогоор дэмжинэ.

#### **Аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэл**

3.7.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, аялал жуулчлалаас орон нутгийн хөгжилд оруулах үр өгөөж нэмэгдэнэ.

3.7.1.Үндэсний өв соёл, ёс заншил, уламжлалаа хадгалан, бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлж, орон нутгийн онцлогт нийцсэн аялал жуулчлал хөгжиж, иргэдэд үзүүлэх, соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ.

3.7.1.1.Соёлын биет болон биет бус өв, түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хадгалах, хамгаалах, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлэн сурталчлах ажлыг олон талын оролцоотой зохион байгуулна.

3.7.1.2.Соёл, урлагийн байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хийж, соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.7.1.3.Бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих олон талт арга хэмжээг зохион байгуулна.

3.7.1.4.Соёл, урлагийн салбарын боловсон хүчнийг чадавхжуулж, гадаад, дотоодын соёлын хамтын ажиллагааг идэвхжүүлэн, соёл урлагийн байгууллага, иргэд, уран бүтээлчдээс гаргасан санал, санаачилгыг дэмжинэ.

3.7.1.5.Аялал жуулчлалыг бүс орон нутгийн онцлогт түшиглэн төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөгжүүлнэ.

### **Шинжлэх ухаан, инновацид суурилсан Ухаалаг хот**

3.8.Орон нутгийн хэмжээнд шинжлэх ухаан, технологи, инновацид суурилсан эдийн засаг хөгжинэ.

3.8.1.Орон нутагт шинээр бий болох инновац, бүтээгдэхүүний нэр төрөл, ажлын байр нэмэгдэнэ.

3.8.1.1.Бүс, орон нутгийн хэмжээнд үйлдвэрлэл, кластер хөгжүүлэх инновацын төсөл, гарааны компанийг инкубатор, технологи дамжуулах үйлчилгээгээр дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

3.8.1.2."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ болон бусад томоохон аж ахуйн нэгжүүдийн ашиглаж буй импортыг орлох бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн судалгааг хийж, бүс нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдэд технологи дамжуулах ажлыг зохион байгуулна.

3.8.1.3.Ухаалаг хотын стандартад нийцсэн дэд системүүдийг нэмэгдүүлж, инновац нэвтрүүлэн дэд бүтцийг өргөтгөх ажлыг зохион байгуулна.

3.8.1.4.Мэдээллийн технологийн сургалт, үйлдвэрлэлийн "Технополис" төслийн I үе шатны ажлыг эхлүүлэх бэлтгэлийг хангана.

### **ДӨРӨВ.ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ЗАСАГЛАЛ**

#### **Хүний эрх, эрх чөлөө**

4.1.Аймгийн хэмжээнд бүх талаар хүний эрх хангагдана.

4.1.1.Төрийн байгууллагуудаас явуулж буй үйл ажиллагааны талаар олон нийтийн мэдлэг, ойлголт нэмэгдэн, хүний эрхийн зөрчил буурсан байна.

4.1.1.1.Хүний эрхийн үндэсний комисс болон бусад байгууллагуудтай хүний эрхийг хангах чиглэлээрх хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

4.1.1.2.Аж ахуйн нэгж байгууллагууд үйл ажиллагаандаа хүний эрхийг дээдлэх, иргэд эрхээ эдлэх нөхцөлийг хангаж байгаа эсэхэд төрөөс тавих хяналтыг сайжруулна.

4.1.1.3.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, бэхжүүлэх, хамгаалах, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар бүх нийтийн жендэрийн талаарх боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.1.1.4.Цагдан хорих, баривчлах байрны нөхцөлийг сайжруулах ажлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.

4.1.1.5.Зөрчлийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулна.

4.1.1.6.Хууль тогтоомжийг сурталчлан бүх нийтийн эрх зүйн болон хүний эрхийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна.

4.1.1.7.Нутгийн захиргааны байгууллагаас шийдвэр гаргахдаа хүний эрхэд суурилсан хандлагыг удирдлага болгон хүний эрхийн зөрчлөөс сэргийлж ажиллана.

#### **Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, ил тод байдал**

4.2.Төрийн үйл ажиллагааны ил тод байдал хангагдан, орон нутгийн өмчит байгууллагын алдагдал буурна.

4.2.1.Иргэний нийгмийн байгууллага болон иргэдийн оролцоо сайжирч, орон нутгийн өмчит байгууллагуудын оновчтой бүтэц бий болж, зохион байгуулалт сайжирна.

4.2.1.1.Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулж, хуулиар хориглосноос бусад мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.

4.2.1.2.Иргэний нийгэм, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, оролцоо, санаачилгыг дэмжих бодлогыг баримтлан төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

4.2.1.3.Орон нутгийн өмчит байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөн, шинэчлэн зохион байгуулна.

#### **Цахим засаглал, төрийн үйлчилгээ**

4.3.Цахим засаглалыг хөгжүүлж төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангана. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, сайжирч, төрийн байгууллага болон үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ.

4.3.1.Чадахуйн зарчимд суурилсан төрийн албыг бэхжүүлж, төрийн үйл ажиллагааны хурд, бүтээмж дээшилж, төрийн үйлчилгээний шуурхай байдал хангагдана.

4.3.1.1.Төрөөс үзүүлж байгаа үйлчилгээнүүдэд процессын шинжилгээ хийж, төрийн үйлчилгээний шат дамжлагыг багасган, шуурхай байдлыг ханган ажиллана.

4.3.1.2.Төрийн байгууллагын цахим дэд бүтцийг хөгжүүлж, мэдээлэл харилцаа холбоо, хиймэл оюун ухаан, шинэ технологийг нэвтрүүлж шийдвэр гаргах үйл явцыг шуурхай, ил тод болгоно.

4.3.1.3.Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 3-аас доошгүй багийн нэгдсэн байрыг шинээр барьж ашиглалтад оруулна.

4.3.1.4.Төрийн үйлчилгээг нэг дороос үзүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор төрийн байгууллагуудын нэгдсэн байрыг барих ажлыг эхлүүлнэ.

4.3.1.5.Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, сургаж хөгжүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг зохион байгуулна.

4.3.1.6.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг сахиулж, хариуцлагыг дээшлүүлнэ.

4.3.1.7.Олон улсын байгууллагууд болон харилцаа, хамтын ажиллагаат гадаад орнуудын муж, хотуудтай нийгэм, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

4.3.1.8.Төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж буй удирдлагын баримтын 60 хувийг цахимжуулж, баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулна.

4.3.1.9.Санхүүгийн төлбөр тооцооны суурь болох төлбөрийн баримтын хэрэглээ, үр нөлөөг сайжруулж, цахим татварын тогтолцооны хүртээмжийг нэмэгдүүлнэ.

#### **Амар тайван, аюулгүй хот**

4.4.Иргэдийн аюулгүй амар тайван амьдрах нөхцөл бүрдэнэ.

4.4.1.Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчил буурна.

4.4.1.1.Олон нийтийг авлигаас ангид байлгах, шударга ёсыг шаардах, авлигыг үл тэвчих сэтгэлгээ, хандлагыг иргэн бүрд төлөвшүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.

4.4.1.2.Эрүүл, аюулгүй орчныг бий болгох зорилгоор дэвшилтэт технологи бүхий камерын хяналтын нэгдсэн системийг суурьшлын бүсийн 80 хувьд хүргэж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

4.4.1.3.Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

4.4.1.4.Согтууруулах ундааны эргэлтэд тавих хяналтыг сайжруулж, архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.

4.4.1.5.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

4.4.1.6.Төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, зарим эрүүгийн хэргийн хохирогч, иргэний болон захиргааны хэргийн оролцогчдод хууль зүйн туслалцаа үзүүлнэ.

4.4.1.7.Хууль сахиулах байгууллагуудын хүний нөөц, техник, тоног төхөөрөмжийг сайжруулах замаар иргэдэд чирэгдэлгүй, шуурхай үйлчлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

4.4.1.8.Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтыг сайжруулна.

#### **Батлан хамгаалах, гамшгийн үеийн бэлэн байдал**

4.5.Аймгийн сөрөн тэсвэрлэх чадавх нэмэгдэнэ.

4.5.1.Аймгийн батлан хамгаалах болон гамшгаас хамгаалах чадавх бэхжиж, гамшгийн бэлэн байдал хангагдана.

4.5.1.1.Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн бэлэн байдлыг хангаж, батлан хамгаалах үйл хэргийг иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулна.

4.5.1.2.Гамшиг, аюулт үзэгдэл, ослыг зарлан мэдээлэх системийг өргөжүүлж, эрсдэлийн мэдээлэлд суурилсан гамшгаас хамгаалах удирдлага, үйл ажиллагааг хэрэгжүүлэн, гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоог дэмжиж ажиллана.

4.5.1.3.Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлнэ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Ээлжит бус III хуралдааны 03/11 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮНГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

№	Үр дүн	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилготой түвшин			Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага		
					2025	2026	2027			2028	Үндсэн	Хамтран
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
<b>Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн</b>												
1	1.1. Аймгийн эдийн засгийн чадамж нэмэгдэнэ.	Аймгийн ДНБ-ний өсөлт	хувь	2023 он 2%	2.5%	2.5%	2.5%	2.5%	Тухайн жилийн өсөлт	Жилд наг удаа	Аймгийн ЗДТГ Статистикийн хэлтэс	Сумдын ЗДТГ Төрийн байгуул-лагууд
2	2.1. Гэр бүлийн гишүүд болон хүн амын бүлгүүдийн нийгмийн оролцоо хангагдана.	Гэр бүл, нийгэм рүү чиглэсэн олон талт нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан иргэд	хувь	30115	Жил бүр 3 хувиар нэмэгдүүлнэ /31921/	Жил бүр 3 хувиар нэмэгдүүлнэ /32825/	Жил бүр 3 хувиар нэмэгдүүлнэ /33728/	Жил бүр 3 хувиар нэмэгдүүлнэ /33728/	Олон талт нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо өссөн дүнгээр	Жилд 1 удаа	НБХ	ХТБХХГ ХХҮГ СУАЖЗГ
3	2.2. Аймгийн хэмжээнд ажилгүйдлийн түвшин буурна.	Ажилгүйдлийн түвшин	Хувь	7.9	7.7	7.5	7.4	7.4	Ажилгүй иргэдийн тоог хөдөлмөрийн насны нийт хүн амтай харьцуулна.	Жилд 1 удаа	НБХ ХХҮГ	Статистикийн хэлтэс
4	2.3 Нийтийн биеийн тамир, спортоор хичээллэгчдийг дэмжиж, хүн амын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлсэн байна.	Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлсэн иргэд	хувь	16.7	16.9	17	17.1	17.1	Аймгийн 3-аас дээш насны иргэдээс идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэгч иргэдийн эзлэх хувь	Жилд 1 удаа	НБХ БТСГ	Сумдын ЗДТГ
5	2.4. Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ.	СӨББ, ЕБС-ийн байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний дундаж	хувь	ЕБС-75.8 СӨББ – 87.8	ЕБС-76.0 СӨББ-88.0	ЕБС-76.4 СӨББ-88.4	ЕБС-76.6 СӨББ-88.6	ЕБС-76.6 СӨББ-88.6	Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулдаг байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний дүнг өссөн дүнгээр тооцов	Хагас, бүтэн жилээр	БГ	НБХ Сумдын ЗДТГ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
6	2.5. Аймгийн хэмжээнд хүн амын дундаж наслалт нэмэгдсэн байна.	Хүн амын дундаж наслалт	жил	73.34	73.43	73.52	73.61	73.7	Төрөлгөөс тооцсон дундаж наслалтын хэмжээ, 2023 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ЭМГ	
7	3.1. Иргэдэд амьдрах таатай орчныг бүрдүүлсэн "Төлөвлөлтэй хот"-ыг бий болгоно.	Инженерийн дэд бүтцэд холбогдсон өрхийн нийт өрхөд эзлэх хувь	хувь	46.8	47.0	48.0	49.0	50.0		Жилд нэг удаа	ГХБХБГ	ХБТХОХ ХЗА ХББЗА
8	3.2. Олон тулгуурт эдийн засагтай үйлдвэрлэгч хот болон хөгжинэ.	Хүнд үйлдвэрлэлийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өсөлт /хим, түлш, резин, хуванцар, төмөрлөг, цахилгаан/	хувь	2023 онд 8%	10%	10%	10%	10%	Тухайн жилийн өсөлт	Жилд нэг удаа	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ ХБТХОХ	ХХААГ Статистикийн хэлтэс
9	3.3. Дэд бүтцийн хүртээмж, найдвартай ажиллагаа нэмэгдэнэ.	Инженерийн шугам сүлжээний шинэчлэлт	хувь	40	45	50	60	70	Хотын нийт инженерийн шугам сүлжээний ИШСүлжээг шинэчлэлт өссөн дүнгээр тооцсон.	Хагас бүтэн жилээр	ХЗА	ХБТХОХ ХББЗА ГХБХБГ ЭУДС ОНӨХ ЭБЦС ТӨХК ЭДЦС ТӨХК
10	3.4. Тээвэр авто замын нөхцөл сайжирснаар иргэдийн ая тухтай, аюул осолгүй зорчих орчин бүрдэнэ.	Авто замын эрчим	тоо	2017 814	814	900	950	1000	Төв авто зам – Баян Төгөл, Горнякийн хэсэгт жилд 1 удаа хөдөлгөөний эрчмийн тооллого хийж гаргах (Хөдөлгөөний эрчим нь 1 цагт дундажар тухайн замаар дамжин өнгөрч буй тээврийн хэрэгслийн тоо)	Жилдээ	МШУТ	ХБТХОХ ХЗА ЦГ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
11	3.5. Хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангана.	Стандартын шаардлага хангасан орон нутгийн хүнсний үйлдвэрлэл зорилгач	тоо	27	30	33	36	39	Өссөн дүнгээр тооцсон.	Жилд 1 удаа	ХБТХОХ	ХХААГ МЭГ СХЭХ
12	3.6. Хүрээлэн буй орчинд зөлтэй "Ногоон хот"-ыг бий болгоно.	Нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээ	М²	9.2	10.5	12.5	14	15	-	1 жилд	ХБТХОХ ХЗА БОГ ЦНБГ	Сумдын ЗДТГ
13	3.7. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, аялал жуулчлалаас орон нутгийн хөгжилд оруулах үр өгөөж нэмэгдэнэ.	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн шийдвэр	тоо	1	3	3	3	3	Жилд Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх чиглэлээр 3 арга хэмжээ тогтмол зохион байгуулна.	Хагас, бүтэн жилээр	СУАЖЗГ	НБХ
14	3.8. Орон нутгийн хэмжээнд шинжлэх ухаан, технологи, инновацид суурилсан эдийн засаг хөгжинэ.	Орон нутагт шинээр бий болсон бүтээгдэхүүний борлуулалтын орлого	сая. төгрөг	1000.0	1500.0	2000.0	2500.0	3000.0	Бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг өссөн дүнгээр тооцсон.	Жилд 1 удаа	ХБТХОХ ШУТП	ТГ Статисти- кийн хэлтэс Аж ахуйн нэгж байгууллага Уд
15	4.1. Аймгийн хэмжээнд бүх талаар хүний эрх хангагдана.	Хүний эрхийг хангах талаар хийсэн хяналт, шалгалт	Тоо	1	1	1	1	1	Тухайн жилд хийх хяналт шалгалтын тоогоор тооцсон	Хагас, бүтэн жилээр	ХЭЭХ ХЗҮК- ийн мэргэ- жилгэн	Нийт төрийн байгуулла- гууд
16	4.2. Төрийн үйл ажиллагааны ил тод байдал хангагдан, орон нутгийн өмчит байгууллагын алдагдал буурна.	Орон нутгийн өмчит байгууллагуудын алдагдал	сая. төгрөг	-1,735.1	-1,683.0	-1,632.5	-1,583.5	-1,536.0	Орон нутгийн өмчит байгууллагуудын алдагдлыг өмнөх оноос 3 хувиар бууруулж хүрэх түвшингээр тооцсон.	Жилд 4 удаа	ОНӨГ	ОНӨБ-УУД
17	4.3. Цахим засаглалыг хөгжүүлж төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангана. Төрийн үйлчилгээний	Төрийн үйлчилгээний талварх судалгааны үр дүн	хувь	59.1	61.0	63.0	65.0	67.0	Хөндлөнгүйн судалгааны байгууллагаар жил бүр сэтгэл ханамжийн судалгааг зохион байгуулна.	Жилдээ	ТЗҮХ	Судалгааны байгууллага

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
	чанар, хүртээмж, сайжирч, төрийн байгууллага болон үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ.								Суурь түвшинг 2023 оны үзүүлэлтээр авсан.			
18	4.4. Иргэдийн өмнөд амьдрах нөхцөл бүрдэнэ.	Гэмт хэргийн илрүүлэлт	хувь	52.7	53.0	53.5	53.7	54.0	Гэмт хэргийн илрүүлэлтийг өссөн дүнгээр тооцсон.	Хагас, бүтэн жилээр	ХЗЗХ	ЦГ
19	4.5. Аймгийн сөрөн тэсвэрлэх чадвар нэмэгдэнэ.	Аймгийн сөрөн тэсвэрлэх чадвар	Хувь	-	2.5%	5%	7.5%	10%	Аймгийн сөрөн тэсвэрлэх чадварыг өссөн дүнгээр тооцно.	Хагас, бүтэн жилээр	ЦШ	Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд
<b>Хөтөлбөрийн үр дүн</b>												
20	1.1.1. Бүс нутгийн нийгэм, эдийн засгийн интеграцид нэгдэн, зах зээлээ тэлнэ.	Аймгийн экспорт	тэрбум төгрөг	5022.5	5524.7	6077.2	6684.9	7353.4	Тухайн жилийн экспорт	Жила нэг удаа	ХБТХОХ СХ	Сумдын ЗДТГ агентлагууд
21	2.1.1. Гэр бүлийн хөгжлийн цогц төвийн ажиллагаа тогтмолжиж, гэр бүлд чиглэсэн олон талт үйл ажиллагааны чанар, хүртээмж нэмэгдэнэ.	Гэр бүлд чиглэсэн арга хэмжээ	тоо	5	6	7	8	9	Тухайн хугацаанд гэр бүл болон хүүхдэд зориулан хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо өссөн дүнгээр тооцсон.	Жилд 1 удаа	ХГБХХГ	Аймаг, сумдын ЗДТГ БГ ЦГ ЭМГ ХХҮГ
22	2.1.2. Ахмад настны хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, асаргаа сувилгааны чанар, хүртээмж сайжирч, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагаа	Ахмад настанд үзүүлэх үйлчилгээнд хамрагдсан ахмад	тоо	Дахардсан тоогоор 43580	Дахардсан тоогоор 44000	Дахардсан тоогоор 44200	Дахардсан тоогоор 44400	Дахардсан тоогоор 44600	Өссөн дүнгээр тооцсон.	Жилд 1 удаа	НБХ	Сумдын ЗДТГ ХХҮГ НДГ Ахмадын хороо



1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
23	өргөжиж нийгмийн оролцоо нэмэгдэнэ. 2.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоо, хөдөлмөр эрхлэх боломж нэмэгдэж, орчны дэд бүтцийн хүртээмж сайжирна.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйлчилгээнд хамрагдсан иргэд	тоо	85	100	105	110	110	Суурь түвшинг сүүлийн 5 жилийн дундаж үзүүлэлтээр тооцсон. Зорилготой түвшинг өссөн дүнгээр тооцсон.	Жилд 1 удаа	ХХҮГ	Аймаг, сумдын ЗДТГ Төрийн байгууллага Уд
24	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн хүний нөөцийн чадавх дээшилж, тогтвортой, өрсөлдөх чадвертай ажлын байрны хүрээ өргөжсөн байна.	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	хувь	46.0	46.0	46.1	46.2	46.3	Хөдөлмөрийн насны хүн амын хэдэн хувийг ажиллагчид эзэлж байгааг харуулна.	Жилд нэг удаа	ХХҮГ	Аймаг, сумдын ЗДТГ Статистикийн хэлтэс
25	2.3.1. Нэг хүнд ноогдох спортын заалны талбайн хэмжээ нэмэгдэнэ.	Спорт заал	тоо	36	-	Жилд 1 нэмэгдэнэ	Жилд 1 нэмэгдэнэ	Жилд 1 нэмэгдэнэ	Шинээр ашиглалтад орсон спорт заалны тоогоор тооцно.	Жилд 1 удаа	БТСГ	НБХ
26	2.4.1. Суралцах таатай орчин бүрдэж, багш, хүүхдийн хөгжил хангагдана.	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж	хувь	ЕБС-75.7 СӨББ-87.8	ЕБС-75.9 СӨББ-88.0	ЕБС-76.1 СӨББ-88.2	ЕБС-76.3 СӨББ-88.4	ЕБС-76.5 СӨББ-88.6	Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулдаг багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дүнг өссөн дүнгээр тооцно.	Хагас, бүтэн жилээр	БГ	НБХ ЕБС СӨББ
27	2.5.1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чадавх бэхжиж, зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчлөлийг	Халдварт өвчний тохиолдол	продецимль	101.7	101.5	98.0	95.6	95.0	/10000 хүн амд ногдох/ 2023 оны суурь түвшин	Жилд 1 удаа	ЭМГ	НБХ Эрүүл мэндийн байгууллага Уд Сумдын ЗДТГ
28		Зурх судасны өвчин, хорт	продецимль	35.4	37.2	37.1	37.0	36.8		Жилд 1 удаа	ЭМГ	НБХ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
	бууруулсан байна.	хавдар, чихрийн шижин болон амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтын баралтын түвшин	тоо	40	40	40	40	40	Тухайн жилд хийгдсэн хяналт	Жилдээ	ГХБХБГ	ХБТХОХ ХББЗА ХЗА
29	3.1.1. Хот байгуулалтын норм дүрмийн хэрэгжилт хангагдана.	Барилга, гадна тохижилт инженерийн дэд бүтцийн төлөвлөлтөд хийгдсэн хяналт	тоо	40	40	40	40	40	Тухайн жилд хийгдсэн хяналт	Жилдээ	ГХБХБГ	ХБТХОХ ХББЗА ХЗА
30	3.2.1. Уул уурхай, үйлдвэрлэлийн салбарыг хослуулан хөгжүүлж импортыг орлох олон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэл хөгжинө.	Боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн өсөлт	хувь	2023 10%	10%	10%	15%	15%	Тухайн жилийн үйлдвэрлэлийн өсөлтийн хувмар тооцов.	Жилд нэг удаа	Аймгийн ЗДТГ	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ ХХААГ ХАУТ Статистикийн хэлтэс
31	3.3.1. Аймгийн хэмжээний эрчим хүч, инженерийн шугам сүлжээний 30-аас доошгүй хувийг шинэчилнэ.	ИШ Сүлжээнд гарсан гэмтэл	тоо	29	27	25	20	18	Тухайн жилд инженерийн шугам сүлжээнд гарсан гэмтлийн тоо	Хагас бүтэн жилээр	ХЗА	ХБТХОХ ХББЗА ГХБХБГ ЭУДТС ОНЭХК ЭВЦТС ТӨХК ЭДЦС ТӨХК
32	3.4.1. Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмж сайжирч, автотээвэр, замын байгууламж нэмэгдэнэ.	Иргэдийн сэтгэл ханамжийн байдал	үнэлгээ	2.56	2.8	3.0	3.2	3.4	Жил бүрийн судалгааны үр дүнгээр	Жилд нэг удаа	ХБТХОХ	АТГ Сумдын ЗДТГ ТББ
33	3.5.1. Хүн амын хүнсний чанар, аюулгүй байдал хангагдана.	Хяналт хэрэгжүүлсэн объектын тоо	тоо	556	659	710	760	810	Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар тооцов.	Жилд 2 удаа	ХХААГ ЭМГ	МЭГ Сумдын ЗДТГ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
34	3.5.2. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, түүхий эд бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлагыг хангана.	Дархлаажуулалтад хамрагдсан малын тоо	тоо	146.5	150.0	150.5	155.0	155.5	Тухайн жилд хамрагдах малын тоогоор тооцов.	Жилд 2 удаа	ХБТХОХ	МЭГ Сумдын ЗДТГ
35	3.6.1. Байгалийн нөөц баялийг зохицтой ашиглуулж нөхөн сэргээлтийг эрчимжүүлэн, хүрээлэн буй орчны бохирдол, доройтол буурна.	Хүлэмжийн хийн ялгарал	мян.тн CO2-эқв	-	Тооцно	3- аас багагүй хувиар бууруулна.	3- аас багагүй хувиар бууруулна.	3- аас багагүй хувиар бууруулна.	2025 онд тооцсон дүнгээс жил бүр 3-аас багагүй хувиар бууруулахаар тооцов.	Жилдээ	ХБТХОХ	БОГ Статистикийн хэлтэс
36	3.7.1. Үндэсний өв соёл, ёс заншил, уламжлалаа хадгалан, бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлж, орон нутгийн онцлог нийцсэн аялал жуулчлал хөгжиж, иргэдэд үзүүлэх, соёл, урлагийн үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэнэ	Соёл, урлаг, аялал, жуулчлалын чиглэлээр орон нутгийн хэмжээнд болон улсын хэмжээнд хэрэгжиж буй тогтоол, шийдвэрийн хэрэгжилт	хувь	93%	95%	96%	96%	96%	Хууль, тогтоол, шийдвэрийн тухайн жилийн хэрэгжилтийн хувь	Хагас, бүтэн жилээр	СУАЖЗГ	НБХ Сумдын ЗДТГ
37	3.8.1. Орон нутаг шинээр бий болох инновац, бүтээгдэхүүний нэр төрөл, ажлын байр нэмэгдэнэ.	Орон нутаг инновац, технологийн салбарт шинээр бий болсон ажлын байр	тоо	50	75	100	125	150	Шинээр бий болсон ажлын байрыг өссөн дүнгээр тооцсон.	Хагас, бүтэн жилээр	ХБТХОХ ШУТП	ХХҮГ Аж ахуйн нэгж байгууллагууд
38	4.1.1. Төрийн байгууллагуудаас явуулж буй үйл ажиллагааны талаар олон нийтийн мэдлэг, ойлголт нэмэгдэн, хүний эрхийн зөрчил буурсан байна.	Хүний эрхийн зөрчлийн талаар ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлт	хувь	90.6	91	92	93	95	Тухайн жилд хүний эрх зөрчигдсөн талаар ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувиар тооцсон.	Жилд 1 удаа	ХЭЗХ	Нийт төрийн байгууллагууд
39	4.2.1. Иргэний нийгмийн байгууллага болон иргэдийн оролцоо	Оновчтой бүтэц зохион байгуулалт хийгдсэн орон нутгийн өмчит байгууллага	Тоо	11	10	9	9	9	Орон нутгийн өмчит 11 байгууллагаас 2 байгууллагыг менежментийн	Жилд 1 удаа	ОНӨГ	ОНӨБ-УУД

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
40	сайжирч, орон нутгийн өмчит байгууллагуудын оновчтой бүтэц бий болж, зохион байгуулалт сайжирна.	Орон нутгийн өмчит байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй байдал	тоо	68	68	68	68	68	Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуулинд заасан мэдээллийг нийтэд мэдээлэхээр тооцсон.	Жилд 1-12 удаа	ОНӨГ	ОНӨБ-ууд
41	4.3.1. Чадахуйн зарчимд суурилсан төрийн албыг бэхжүүлж, төрийн үйл ажиллагааны хүрд, бүтээмж дээшилж, төрийн үйлчилгээний шуурхай байдал хангагдана.	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс гаргасан гомдол	тоо	157	152	147	145	140	Тухайн жилд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол	Жилд 1 удаа	ТЗУХ	Төрийн байгууллагууд
42	4.4.1. Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчил буурна.	Тухайн жилд нийт бүртгэгдсэн гэмт хэрэг зөрчил	тоо	Гэмт хэрэг 790 Зөрчил 37909	Гэмт хэрэг 785 Зөрчил 37600	Гэмт хэрэг 780 Зөрчил 37300	Гэмт хэрэг 775 Зөрчил 37000	Гэмт хэрэг 770 Зөрчил 36500	Тухайн жилд бүртгэгдсэн гэмт хэрэг зөрчлийн тоогоор тооцсон.	Хагас бүтэн жилээр	ХЭЗХ	ЦГ
43	4.5.1. Аймгийн бэлэн хамгаалах болон гамшгаас хамгаалах чадавч бэхжиж, гамшгийн бэлэн байдал хангагдана.	Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн бэлэн байдал	хувь	5%	7,5%	10%	1,25%	15%	Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн бэлэн байдлыг өссөн дүнгээр тооцно.	Хагас бүтэн жилээр	ЦШ	Зэвсэгт хүчний 186 дугаар анги
<b>Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа</b>												
44	1.1.1.1. Эсийн баяжмал хайлуулах, боловсруулах, химийн үйлдвэр болон бусад дагалдах үйлдвэр бүхий технологийн парк байгуулна.	Бүрэн хэрэгжсэн төсөл	Тоо	2024 1	-	2	3	5	Өссөн дүнгээр	Жилд 2 удаа	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	Аймгийн ЗДТГ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
45	1.1.1.2. "Сургалт-Эрдэм шинжилгээ-Үйлдвэрлэлийн Цогцолбор" хотхоныг байгуулан шинжлэх ухаанд суурилсан оюуны үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд Дэмжлэг үзүүлнэ.	Төслийн хэрэгжилт	хувь	2024 онд 0	5	10	15	20	Өссөн дүнгээр	Жилд 2 удаа	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	Аймгийн ЗДТГ
46	1.1.1.3. Шилжэн ирж суурьшиж иргэдэд ажиллаж амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэн хүн амыг нэмэгдүүлнэ.	Хүн амын жилийн өсөлт	хувь	2024 онд 1.1	2.0	2.0	2.0	2.0	Суурь түвшин урьдчилсан тооцооллоор	Жилд нэг удаа	ХБТХОХ Статистикийн хэлтэс УБХ	Сумдын ЗДТГ Төрийн байгууллагууд
47	1.1.1.4 Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг түшиглэн төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг өргөжүүлж "Хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналт-сэргийлэлтийн төв" байгуулна.	Төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээнд хамрагдсан иргэн	тоо	70	80	80	90	100	Тухайн жилд эмчилгээ, үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоогоор тооцсон.	Хагас, бүтэн жилээр	ЭМГ	НБХ БОЭТ
48	1.1.1.5. Тээвэр логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлж, бүсийн импорт, экспортын тээвэрлэлтийн зангилаа хот болон хөгжинэ.	Ачаа эргэлт	сая.тн. км	2023 онд 929.4	940.0	950.0	970.0	1000.0	Тухайн жилийн гүйцэтгэлээр	Улирал бүр	ХБТХОХ ГХБХБГ	ЭЗХЯ
49	2.1.1.1. Гэр бүлийн хөгжлийн цогц төвийг байгуулан ажиллуулж, гэр бүлд суурилсан хүний хөгжил, оролцоог	Гэр бүлийн хөгжлийн цогц төв байгуулна.	ажлын явц	-	Гэр бүлийн цогц төв байгуулна.	Гэр бүлийн хөгжлийн цогц төвийн үйл ажиллагааг эхлүүлнэ.	Гэр бүлийн хөгжлийн цогц төвийн үйл ажиллагаа тогтворжино.	Гэр бүлийн хөгжлийн цогц төвийн үйл ажиллагаа тогтворжино.	-	Жилд 1 удаа	ХГБХХГ Гэр бүлийн хөгжлийн цогц төв	НБХ
50		Хүн амын бүлгүүдийн	хувь	-	Хөтөлбөрийг боловсруулан	50.0	80.0	100.0	Хөтөлбөрийн хэрэгжилтийн	Жилд 1 удаа	НБХ	Сумдын ЗДТГ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
	нэмэгдүүлэх "Хүн амын бүлгүүдийн хөгжил"-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэн гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт			батлуулна.				хувийг өссөн дүнгээр тооцов.			Төрийн байгууллагыг УА
51	2.1.1.2. Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн, гэр багуудад хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллуулж салбар дундын болон хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулна.	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлт болон үйлчилгээнд хамрагдсан хүүхэд	хувь	Эрсдэлийн программд бүртгэлтэй 606 хүүхдийн 81 хувьд хүрч ажилласан.	Эрсдэлийн программд бүртгэлтэй хүүхдүүдийн 83 хувьд хүрч үйлчилнэ.	Эрсдэлийн программд бүртгэлтэй хүүхдүүдийн 85 хувьд хүрч үйлчилнэ.	Эрсдэлийн программд бүртгэлтэй хүүхдүүдийн 87 хувьд хүрч үйлчилнэ.	Эрсдэлийн программд бүртгэлтэй хүүхдүүдийн 89 хувьд хүрч үйлчилнэ.	Эрсдэлийн программд бүртгэлтэй нийт хүүхдээс үйлчилгээ үзүүлсэн хүүхдийн хувиар, өссөн дүнгээр илэрхийлнэ.	Жилд 1 удаа	ХГБХХГ	Аймаг, сумдын ЭДТГ БГ ЦГ ЭМГ ХХУГ ШШГГ ШУХ ГГ СУАЖЗГ
52	2.1.1.3. Хүүхэд харах болон өдөр өнжүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн хөгжлийг дэмжих арга хэмжээг төр, хувийн хэвшлилтэй хамтран хэрэгжүүлнэ.	Хүүхэд харах болон өдөр өнжүүлэх үйлчилгээнд хамрагдсан хүүхэд	тоо	15	20	35	40	45	Тухайн жилд хамрагдах хүүхдийн тоогоор тооцов.	Жилд 1 удаа	ХГБХХГ БГ	НБХ
53	2.1.1.4. Залуучуудын боловсрол, хөгжилд дэмжлэг үзүүлэх, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоог хангах бодлогыг хэрэгжүүлнэ.	Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон залуучууд	хувь	10560	11616 /10 хувиар нэмэгдүүлнэ./	12672 /10 хувиар нэмэгдүүлнэ./	13728 /10 хувиар нэмэгдүүлнэ./	14784 /10 хувиар нэмэгдүүлнэ./	Нийт залуучуудаас Олон нийтийн үйл ажиллагаанд хамрагдсан залуучуудын эзлэх хувиар тооцсон	Жилд 1 удаа	СУАЖЗГ	БГ сумдын ЭДТГ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
